

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/10/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа.....	17
4.2 Төлбөрийн акт	18
4.3 Албан шаардлага	18
4.4 Зөвлөмж	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/63
танай _____ -ны № _____ -т

ТӨВ АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Н.ЭНХТАЙВАН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

19020256

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэ	Эцсийн үлдэгдэ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	587,708,623.95	1,991,525,543.91
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	6,276,588.47
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	6,276,588.47
3121	Төгрөг	00.00	6,276,588.47
31211	Төрийн сангийн харилцах	00.00	5,126,252.47
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	1,150,336.00
33	АВЛАГА	00.00	1,007,087,899.72
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	9,505,161.72
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	997,582,738.00
35	БАРАА МАТЕРИАЛ	587,708,623.95	978,161,055.72
351	Түүхий эд материал	390,756,271.33	765,349,713.30
35110	Тусгай зориулалттай материал	154,556,789.76	199,618,802.31
35130	Эм боох материал	236,199,481.57	565,730,910.99
354	Хангамжийн материал	196,952,352.62	212,811,342.42
35410	Бичиг хэргийн материал	2,011,200.00	1,308,000.00
35420	Аж ахуйн материал	2,717,220.00	1,489,100.00
35440	Түлш, шатах тослох материал	689,080.00	00.00
35460	Хүнсний материал	10,327,675.20	3,054,868.00
35470	Бусад хангамжийн материал	181,207,177.42	206,959,374.42
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,393,721,057.13	12,034,622,294.62
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,393,721,057.13	12,034,622,294.62
392	Биет хөрөнгө	8,702,326,084.89	11,344,438,377.89
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,056,893,779.00	7,401,893,779.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-450,109,615.08	-650,446,467.24
39203	Авто-тээврийн хэрэгсэл	257,396,077.00	298,193,934.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-174,151,937.55	-188,810,658.70
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	4,842,110,223.03	8,070,504,260.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	-2,982,359,134.05	-3,734,012,897.69
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	221,249,217.10	242,370,347.10
39208	Хуримтлагдсан элэгдэл	-165,361,176.37	-181,811,368.24
39209	Зам, гүүрийн байгууламж	212,268,121.00	212,268,121.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-141,849,824.88	-155,533,484.04
39214	Бусад үндсэн хөрөнгө	55,837,224.00	64,202,224.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-30,001,868.31	-34,784,412.15
39217	Ном	405,000.00	405,000.00
393	Биет бус хөрөнгө	691,394,972.24	690,183,916.73
39301	Програм хангамж	75,399,500.00	75,399,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-73,454,527.76	-74,665,583.27
39303	Бусад биет бус хөрөнгө	689,450,000.00	689,450,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9,981,429,681.08	14,026,147,838.53
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	1,059,980,006.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	1,059,980,006.50
413	Өглөг	00.00	1,059,980,006.50
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	1,059,980,006.50
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,981,429,681.08	12,966,167,832.03
51	Засгийн газрын хувь оролцоо	9,981,429,681.08	12,966,167,832.03
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	4,497,859,191.42	4,497,859,191.42
51101	Өмч: - төрийн	4,497,859,191.42	4,497,859,191.42
512	Хуримтлагдсан үр дүн	1,003,709,624.05	3,988,447,775.00
51210	Өмнөх үеийн үр дүн	1,003,709,624.05	1,003,709,624.05
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	2,984,738,150.95
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,479,860,865.61	4,479,860,865.61
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9,981,429,681.08	14,026,147,838.53

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны коды	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,020,892,510.40	15,691,628,029.62
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	496,237,482.40	4,729,235,181.12
120	Нийтлэг татварын бус орлого	496,237,482.40	4,729,235,181.12
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	139,504,830.00	125,139,150.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	139,504,830.00	125,139,150.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	00.00	3,531,936,987.82
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	00.00	1,072,159,043.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,524,655,028.00	10,962,392,848.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,140,651,500.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,140,651,500.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	166,189,972.00	593,066,178.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив,	2,350,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц	12,281,572.00	133,239,919.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс	00.00	416,613,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий	151,558,400.00	41,218,259.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	00.00	1,995,000.00
1330	Төсвийн захирагчдаас	00.00	500,000,000.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	00.00	200,000,000.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00.00	300,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,217,813,556.00	9,869,326,670.50
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,217,813,556.00	9,869,326,670.50
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	9,180,282,999.89	12,706,889,878.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,180,282,999.89	12,706,889,878.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,172,650,777.29	12,285,469,497.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,058,854,503.84	5,806,547,899.80
210101	Үндсэн цалин	2,698,435,161.00	2,679,387,376.80
210102	Нэмэгдэл	1,958,988,980.84	2,703,179,925.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	171,913,605.00	160,598,118.00
210104	Урамшуулал	229,516,757.00	263,382,480.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	651,035,958.91	770,493,172.87
210201	Тэтгэврийн даатгал	458,671,342.00	544,719,421.88
210202	Тэтгэмжийн даатгал	48,669,042.81	58,720,838.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	38,725,418.83	46,708,511.67
210204	Ажилгүйдлийн даатгал	9,458,097.67	10,886,999.86
210205	Эрүүл мэндийн даатгал	95,512,057.60	109,457,401.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	613,994,127.50	702,992,079.00
210301	Гэрэл, цахилгаан	92,475,914.00	91,960,086.00
210302	Түлш, халаалт	442,302,519.50	443,360,269.00
210303	Цэвэр, бохир ус	79,215,694.00	167,671,724.00
2104	Хангамж, бараа материалын зардал	165,934,487.85	209,334,684.64
210401	Бичиг хэрэг	22,982,357.60	29,182,380.00
210402	Тээвэр, шатахуун	60,419,360.00	80,689,080.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,880,231.75	9,110,339.64
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	56,779,330.00	79,344,560.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,873,208.50	11,008,325.00
2105	Нормативт зардал	1,737,848,180.64	3,608,859,008.03
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,560,547,611.34	3,292,173,272.83
210502	Хоол, хүнс	155,189,869.30	307,944,507.20
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	22,110,700.00	8,741,228.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	77,981,060.01	73,636,948.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	397,000.00	1,062,950.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	13,070,805.00	2,499,500.00
210604	Урсгал засвар	64,513,255.01	70,074,498.00
2107	Томилолт, зочны зардал	2,982,000.00	668,000.00
210702	Дотоод албан томилолт	2,982,000.00	668,000.00

Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	75,855,503.00	71,730,325.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	59,495,800.00	61,067,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,200,000.00	2,056,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	941,685.00	632,025.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	359,400.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	180,000.00	220,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,628,000.00	5,556,450.00
210807	Газрын төлбөр	2,027,925.00	1,977,750.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	217,000.00	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	6,805,693.00	220,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	788,164,955.54	1,041,207,380.33
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	17,743,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	992,500.00	985,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	787,172,455.54	1,022,478,930.33
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,632,222.60	421,420,381.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,133,626.00	421,420,381.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,133,626.00	421,420,381.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,498,596.60	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,498,596.60	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-159,390,489.49	2,984,738,150.95
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,782,678.22	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3,782,678.22	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-3,782,678.22	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-163,173,167.71	2,984,738,150.95

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,497,859,191.42	4,479,860,865.61	1,166,882,791.76	00.00	10,144,602,848.79
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,497,859,191.42	4,479,860,865.61	1,166,882,791.76	00.00	10,144,602,848.79
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз,	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-163,173,167.71	00.00	-163,173,167.71
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,497,859,191.42	4,479,860,865.61	1,003,709,624.05	00.00	9,981,429,681.08
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,497,859,191.42	4,479,860,865.61	1,003,709,624.05	00.00	9,981,429,681.08
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,497,859,191.42	4,479,860,865.61	1,003,709,624.05	00.00	9,981,429,681.08
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз,	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,984,738,150.95	00.00	2,984,738,150.95
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,497,859,191.42	4,479,860,865.61	3,988,447,775.00	00.00	12,966,167,832.03

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	8,664,159,858.00	10,091,485,791.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	139,504,830.00	125,139,150.00
120	Нийтлэг татварын бус орлого	139,504,830.00	125,139,150.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	139,504,830.00	125,139,150.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	139,504,830.00	125,139,150.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,524,655,028.00	9,966,346,641.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,140,651,500.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,140,651,500.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	166,189,972.00	593,066,178.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,350,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,281,572.00	133,239,919.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	416,613,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	151,558,400.00	41,218,259.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	00.00	1,995,000.00
1330	Төсвийн захирагчдаас	00.00	500,000,000.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	00.00	200,000,000.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00.00	300,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,217,813,556.00	8,873,280,463.50
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	1,536,531.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,217,813,556.00	8,871,743,932.50
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	8,411,127,087.00	9,953,766,023.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,411,127,087.00	9,953,766,023.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,403,314,864.40	9,536,180,442.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,058,854,503.84	5,805,272,172.80
210101	Үндсэн цалин	2,698,435,161.00	2,689,788,348.80
210102	Нэмэгдэл	1,958,988,980.84	2,691,503,226.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	171,913,605.00	160,598,118.00
210104	Урамшуулал	229,516,757.00	263,382,480.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	651,035,958.91	782,441,592.59
210201	Тэтгэврийн даатгал	458,671,342.00	556,667,841.60
210202	Тэтгэмжийн даатгал	48,669,042.81	58,720,838.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	38,725,418.83	46,708,511.67
210204	Ажилгүйдлийн даатгал	9,458,097.67	10,887,000.06
210205	Эрүүл мэндийн даатгал	95,512,057.60	109,457,400.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	613,994,127.50	00.00
210301	Гэрэл, цахилгаан	92,475,914.00	00.00
210302	Түлш, халаалт	442,302,519.50	00.00
210303	Цэвэр, бохир ус	79,215,694.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	153,524,271.75	00.00
210401	Бичиг хэрэг	11,717,270.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	61,108,440.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,524,931.75	00.00
210404	Ном, хэвлэл	597,280.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	27,442,260.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	45,134,090.00	00.00
2105	Нормативт зардал	1,729,832,142.40	00.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,534,625,267.40	00.00
210502	Хоол, хүнс	162,764,530.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	32,442,345.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	102,386,450.00	353,870.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	45,738,360.00	00.00
210602	Тавилга	336,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,850,000.00	00.00
210604	Урсгал засвар	50,462,090.00	353,870.00

Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	2,982,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	2,982,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	89,712,910.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	59,395,800.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,200,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	941,685.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	359,400.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	180,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,366,900.00	00.00
210807	Газрын төлбөр	2,027,925.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	217,000.00	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,024,200.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	992,500.00	2,948,112,806.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	2,948,112,806.64
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	992,500.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,812,222.60	417,585,581.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,313,626.00	417,585,581.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,313,626.00	417,585,581.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,498,596.60	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,498,596.60	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	253,032,771.00	137,719,768.47
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	253,032,771.00	131,443,180.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	253,032,771.00	131,443,180.00
2200	Дотоод эх үүсвэрээр	253,032,771.00	131,443,180.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	253,032,771.00	131,443,180.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-253,032,771.00	-131,443,180.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	6,276,588.47
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	6,276,588.47

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,941,983,000.00	9,493,293,361.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,941,983,000.00	9,493,293,361.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,936,143,000.00	9,493,293,361.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,282,216,500.00	5,803,695,159.80
210101	Үндсэн цалин	2,690,722,800.00	2,688,211,335.80
210102	Нэмэгдэл	1,865,229,300.00	2,691,503,226.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	211,365,000.00	160,598,118.00
210104	Урамшуулал	514,899,400.00	263,382,480.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	713,099,200.00	782,228,696.59
210201	Тэтгэврийн даатгал	501,810,600.00	556,454,945.60
210202	Тэтгэмжийн даатгал	52,822,200.00	58,720,838.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	42,257,700.00	46,708,511.67
210204	Ажилгүйдлийн даатгал	10,564,400.00	10,887,000.06
210205	Эрүүл мэндийн даатгал	105,644,300.00	109,457,400.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	742,258,100.00	00.00
210301	Гэрэл, цахилгаан	109,265,400.00	00.00
210302	Түлш, халаалт	457,331,700.00	00.00
210303	Цэвэр, бохир ус	175,661,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	194,512,000.00	00.00
210401	Бичиг хэрэг	11,469,700.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	90,360,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,575,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	39,207,200.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	42,900,100.00	00.00
2105	Нормативт зардал	1,733,700,600.00	00.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,538,306,900.00	00.00
210502	Хоол, хүнс	155,657,500.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	39,736,200.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	149,384,500.00	00.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	78,135,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,850,000.00	00.00
210604	Урсгал засвар	65,399,500.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	7,951,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	7,951,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	109,521,100.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	72,010,600.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,294,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	892,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	356,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,594,800.00	00.00
210807	Газрын төлбөр	2,029,600.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	300,000.00	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	11,044,100.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,500,000.00	2,907,369,504.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	2,907,369,504.64
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,500,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,840,000.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,840,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,840,000.00	00.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,941,983,000.00	9,496,883,082.50
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,361,123,300.00	897,597,460.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	5,361,123,300.00	897,597,460.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,450,000,000.00	8,474,146,472.50
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,450,000,000.00	8,474,146,472.50
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	130,859,700.00	125,139,150.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	130,859,700.00	125,139,150.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	292.00	326.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	215.00	265.00
620003	Үйлчлэх ажилтан	76.00	60.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	165,804,896.00	591,915,842.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	165,804,896.00	591,915,842.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	165,304,896.00	174,330,261.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	42,397,415.00	1,577,013.00
210101	Үндсэн цалин	42,397,415.00	1,577,013.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,281,076.00	212,896.00
210201	Тэтгэврийн даатгал	5,281,076.00	212,896.00
2105	Нормативт зардал	90,544,380.00	00.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	89,631,880.00	00.00
210502	Хоол, хүнс	912,500.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,389,350.00	353,870.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,784,900.00	00.00
210602	Тавилга	2,990,000.00	00.00
210604	Урсгал засвар	12,614,450.00	353,870.00
2107	Томилолт, зочны зардал	1,140,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	1,140,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	2,552,675.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,200,000.00	00.00
210807	Газрын төлбөр	297,675.00	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,055,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	172,186,482.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	172,186,482.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,000.00	417,585,581.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	417,585,581.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	417,585,581.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	166,189,972.00	593,066,178.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	166,189,972.00	593,066,178.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,350,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,281,572.00	133,239,919.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	416,613,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	151,558,400.00	41,218,259.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого		1,995,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны мэдээлэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Майцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн 29 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Нэгдсэн эмнэлэг нь хоёр дугаар шатны тусламж үйлчилгээг үзүүлдэг Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Аймгийн иргэдэд анхдагч болон хоёрдогч шатлалын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх
- Өвчин эмгэг, бэртэл гэмтэл, хүний биеийн үйл ажиллагааны алдагдлыг орчин үеийн анагаах ухаанд тулгуурлан оношлох, эмчлэх, сувилах, хөнгөвчлөх, сэргээн засах эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээг үзүүлэх.
- Аймгийн хүн амын эрүүл урт наслалт дундаж наслалтыг нэмэгдүүлэхийг зорьж, эмнэлгийн тусламж үйлчилгээг хүн амд тэгш хүртээмжтэй, чанартай үзүүлэх.
- Хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж, хүн амын эрүүл мэндийн шинэ эрэлт хэрэгцээнд тулгуурлан, эмнэлгийн тусламж үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Нэгдсэн эмнэлгийн даргын 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн А/35 дугаар тушаалаар "хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод хяналтыг зохион байгуулах" журмыг болон ажлын хэсгийг батлан мөрдөж байна.

Дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 12 арга хэмжээтэйгээр боловсруулж, батлуулан ажилласнаас 11 арга хэмжээг хэрэгжүүлэн 91,0 хувийн гүйцэтгэлтэй байна. Дотоод хяналтын тайланг танилцан, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар зөвлөмж өгч ажилласан байна.

Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний нийт зарлагаас 1,5 хувиар буюу 126,166.9 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 94,625.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний нийт зардлаас тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний нийт зарлагаас 1,5 хувиар буюу 151,278.1 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 113,458.6 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 25,111.2 мянган төгрөгөөр өссөн байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Нэгдсэн эмнэлэг 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хуулиуд болон Эрүүл мэндийн даатгалын Үндэсний Зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 03 дугаар тогтоолыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн алба нь "Payroll", "Acolous" санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд улсын төсвөөс 897,597.5 мянган төгрөг буюу эхний 3 сарын санхүүжилтийг авч, Эрүүл мэндийн даатгалын сангаас 8,474,145.5 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангаас 1,536.5 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоор 125,139.2 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд 593,066.2 мянган төгрөг, нийт 10,091,485.8 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 9,953,766.0 мянган төгрөгийг урсгал зардалд, 131,443.2 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр 131,443.2 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй буюу хандив тусламжаар 3,531,936.9 мянган төгрөгийн, нийт 3,663,380.2 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэж, аймгийн ИТХ-ын шийдвэрээр 19,702.2 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгслийг актлан данснаас хасалт хийж тайлагнасан байна.

Бараа материалын дансанд төсвийн хөрөнгөөр 3,172,709.8 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй 1,072,159.1 мянган төгрөгийн, нийт 4,244,868.9 мянган төгрөгийн орлогыг бүртгэж, 3,834,117.1 мянган төгрөгийн зарцуулж, 20,305.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгаж тайлагнасан.

Авлага, өглөгийн талаар:

Авлага жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 1,007,087.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсанаас ЭМД-аас 997,582.7 мянган төгрөгийн, Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 9,505.2 мянган төгрөгийн авлага шинээр үүсгэсэн байна. Энэ нь ЭМД-ийн ҮЗ-ийн 03 дугаар тогтоолын дагуу гүйцэтгэлээр санхүүжих тогтолцоонд шилжсэнтэй холбоотой 1,007,087.9 мянган төгрөгийн авлага үүссэний 82,2 хувь буюу 819,757.0 мянган төгрөг нь ковидоор хэвтэн эмчлүүлсэн зардлын авлага байна

Өглөг оны эцэст 1,059,980.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь Эрүүл мэндийн даатгалын Үндэсний Зөвлөлийн 03 тоот тогтоолын дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих төлбөртэй үйлчилгээний санхүүжилт дутуу хийгдсэнээс түлш халаалтын 120,000.0 мянган төгрөг, Эм, эмнэлгийн хэрэгслийн 939,980.0 мянган төгрөгийн өр үүссэн байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн харилцах дансанд 5,126.3 мянган төгрөгийн, нэмэлт санхүүжилтийн дансанд 1,150.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Бараа материал 978,161.1 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 12,034,622.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөг/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		6,276.6	6,276.6
Авлага	0	1,007,087.9	1,007,087.9
Урьдчилгаа	0	0	
Бараа материал	587,708.6	978,161.1	390,452.5
Үндсэн хөрөнгө	9,393,721.1	12,034,622.3	2,640,901.2
Нийт хөрөнгө	9,981,429.7	14,026,147.8	4,044,718.1
Өр төлбөр		1,059,980.0	1,059,980.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	9,981,429.7	12,966,167.8	2,984,738.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	9,981,429.7	14,026,147.8	4,044,718.1

Бараа материалын дансны үлдэгдэл 978,161.1 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 390,452.5 мянган төгрөгөөр өссөн нь эмийн үнийн өсөлт, ЭМЯ-аас хуваарилан ирүүлсэн эм, эмнэлгийн хэрэгслийн нийлүүлэлт оны эцэст ирж, бараа материалын үлдэгдэл өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 12,034,622.3 мянган төгрөг болж 2,640,901.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 3,663,380.2 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгийн орлого нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 12,966,167.8 мянган төгрөг болж, 2,984,738.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 10,130,769.5 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,188,786.5 мянган төгрөгөөр бууруулан 8,941,983.0 мянган төгрөгийг урсгал зардалд санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь багаж, хэрэгслийн болон урсгал засварын зардал хасагдсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 897,597.5 мянган төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 8,474,146.5 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогоос 125,139.2 мянган төгрөгийн, нийт 9,496,883.1 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, 9,491,756.8 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 5,126.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 9,491,756.8 мянган төгрөг буюу 99,9 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс Ковид 19 цар тахлын хариу арга хэмжээнд зориулан 140,529.9 мянган төгрөг, Эрүүл мэндийн ажилтны тэтгэмжид 416,613.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн яамнаас бие даасан тогтолцооны сургалтын зардал 3,725.0 мянган төгрөг, Улсын 2 дугаар төв эмнэлэгт ковид 19 цар тахлын лабораторийн шинжилгээнд дайчлагдан ажилласан 2 хүний цалин 1,789.9 мянган төгрөг, Ковид 19 цар тахлын хариу арга хэмжээ эрт илрүүлэх түргэвчилсэн оношлуурын орлого 17,225.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 13,183.4 мянган төгрөг, нийт 593,066.2

мянган төгрөгийг төвлөрүүлж, зарцуулалтын эрхийн хүсэлт гарган 591,915.8 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 1,150.4 төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн яамнаас 2,634,110.4 мянган төгрөг, аймгийн Эрүүл мэндийн газраар дамжиж 484,913.4 мянган төгрөг, хувь хүн, олон нийтийн байгууллагаас 46,088.2 мянган төгрөг, тасаг, нэгжийн хандиваар 14,530.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 7,290.0 мянган төгрөг, нийт 3,186,936.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан. Төсвийн хөрөнгөөр буюу аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 92,790.3 мянган төгрөг, батлагдсан төсвийн дагуу багаж тоног төхөөрөмжийн, тавилга эд хогшлын зардлаас 38,652.9 мянган төгрөгийн, нийт 131,443.2 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж тайлагнасан байна.

ЭМЯ, Эрүүл мэндийн газрын хөрөнгийн нийлүүлэлтийг тулган шалгахад ЭМЯ-ны 2021 оны 10 дугаар сарын 27-ний А/644 дугаар тушаалаар ирүүлсэн 42,633.8 мянган төгрөгийн мэдээллийн систем, телемедициний орох гарах зам, VPN хэрэглэгч гэх хөрөнгө ирээгүй байна. Эрүүл мэндийн газраас ирүүлсэн хөрөнгийг тооцоо үүсгэн бүртгэсэн.

3.8 Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын Үндэсний Зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 03 тоот тогтоолын дагуу гүйцэтгэлээр санхүүжих тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор улсын төсвийн санхүүжилт зогсож, цалин, шимтгэлийн зардлаас бусад зардлууд, зардлын ангилалгүйгээр бараа үйлчилгээний бусад зардлаар зарцуулагдсан байна. Нийт зардлын 56,4 хувь нь ажиллагсадтай холбоотой цалин, шимтгэлийн зардал, 30,1 хувийг эм, эмнэлгийн хэрэгсэл, хоолны зардал эзэлж байна.

Ковид-19 цар тахлын улмаас 2021 оны 01 дүгээр сараас эхлэн улс орон даяар хөл хорио тогтоож, эмнэлгийн үйл ажиллагаа хязгаарлагдсанаар үйлчлүүлэгчийн тоо буурсантай холбоотойгоор өөрийн орлогын төлөвлөгөө 5,720.0 мянган төгрөгөөр буюу 4,4 хувиар тасарсан байна.

Гамшгийн бэлэн байдал зарлан эмнэлгийн ор хүрэлцэхгүйгээс Ар жанчивлан рашаан сувилал, Хүмүүн цогцолбор дунд сургууль, Монгол Кувейтийн байгаль хамгаалах хүрээлэн зэрэг 3 газарт нэмэлтээр ор дэлгэн ажиллуулсан. Үүнтэй уялдан өмнөх оноос эмийн зардал 2.1, хоолны зардал 2.0 дахин өссөн байна.

Эрүүл мэндийн даатгалын Үндэсний Зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 03 тоот тогтоолын дагуу Эрүүл мэндийн даатгалаас санхүүжих төлбөрт үйлчилгээний санхүүжилт цаг хугацаандаа ирээгүйгээс шалтгаалан, жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 1,007,087.9 мянган төгрөгийн авлага, 1,059,980.0 мянган төгрөгийн өр шинээр үүссэн байна. ЭМД-аас санхүүжих төлбөрт үйлчилгээний 997,582.7 мянган төгрөгийн авлага үүссэний 82,2 хувь буюу 819,757.0 мянган төгрөг нь ковидын хэвтэн эмчлүүлсэн үйлчилгээний авлага байна.

Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан цалин, нэмэгдэл урамшууллын зардалд горим сорил хэрэгжүүлээгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан

байна. Худалдан авах ажиллагаа, тендер сонгон шалгаруулалт нь гүйцэтгэлийн аудитад хамрагдах болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансанд мэдээлбэл зохих 172 мэдээллээс 2 мэдээллийн хугацаа болоогүй, 101 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 55 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан, 14 мэдээллийг огт байршуулаагүй байна. Шилэн дансанд байгууллагын даргын нэрийг солиогүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 3 зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 10 дугаар сарын 13-ний өдрийн 06/444 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй байна. Хүнс, шатахууны тооцоо бодолтыг давтан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 674,635.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 137,702.0 мянган төгрөгийн алдааг залруулж, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд 536,933.9 мянган төгрөгийн албан шаардлага, шилэн дансны мэдээлэл байршуулсан зөрчилд зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн болон мөнгөн гүйлгээний тайланд 140020 бусад орлогоор 6,252.5 мянган төгрөгийг буруу, санхүү байдлын тайланд бараа материалын үлдэгдлийг 6.3 мянган төгрөгөөр зөрүүтэй, мөнгөн гүйлгээний тайланд төсвийн хөрөнгөөр биет хөрөнгө бэлтгэсэн 131,443.2 мянган төгрөгийг биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардалд тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл

хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралт батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар" -ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн “оршин байх”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт бичигдээгүй.

4.3 Албан шаардлага

АШБ-ын бүрдүүлэлтийг харилцагч байгууллагаас ирүүлсэн е баримттай тулган шалгахад 536,933.9 мянган төгрөгийн гүйлгээ е баримтын дүнгээс зөрүүтэй, бараа материалын анхан шатны баримтын бүрдэл дутуу, гарын үсэг зурж, тэмдэг дарж албажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалын НХМаягт 5 “Төлбөрийн баримт нь ... Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд ...” гэж санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Шилэн дансанд мэдээлбэл зохих 172 мэдээллээс 2 мэдээллийн хугацаа болоогүй, 101 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 55 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан, 14 мэдээллийг огт байршуулаагүй байна. Шилэн дансанд байгууллагын даргын нэрийг солиогүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" зарчмуудыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв байршуулж мэдээлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Нэгдсэн эмнэлэг	4	674,635.9	2	137,702.0	0	0	1	536,933.9	1	0